

Ж.Цэвээн бол Монголын
сэтгүүл зүйг үндэслэгч мөн

Т. Баасансүрэн*

* Сэтгүүл зүй судлаач, дэд доктор

Монгол Улсад өнөөдөр мянга гаруй сонин, сэтгүүл гарч байна. Энэ бол Монголд ардчилсан чөлөөт хэвлэл үүсэн төлөвшсөний үр дүн гэх зэргээр энд тэндгүй бичиж ярих болжээ. Тэр нь үнэн бөгөөд ерээд онд манайд хэрэгжсэн ардчилал, шинэчлэлийн бодит үр дүн яах аргагүй мөн. Эрх, эрх чөлөө, ардчилал, ардчилсан чөлөөт хэвлэл жинхэнэ утгаараа бүрэлдэн төлөвших үндэс суурь тавигдсан юм.

Тэгэхдээ энэ бүхэн хоосон орон зай дээр гэнэт үүсээгүй. Тэнгэрээс хишиг болж унаагүй, газраас хөрс шим авч ургаж төлжсөнийг тэр бүр эргэцүүлж боддоггүйд хамаг учир оршино. “Хоёр хувьсгалыг байгуулахад хосгүй гавьяа байгуулсан сонин”, “Монголын чөлөөт ардчилсан хэвлэлийн загалмайлсан эцэг” хэмээх өгүүллүүддээ би Монголд чөлөөт хэвлэл үүсэн төлөвшихөд жишээлбэл “Үнэн” сонины гүйцэтгэсэн үүргийг үнэн мөнөөр нь нэмж чимэлгүй дурдаж тэмдэглэсэн. Монголын хэвлэлийн түүхэнд “Монголын үнэн” сонин нь нийгмийн байгууллыг хүчээр өөрчлөх зэвсэгт тэмцэлд шууд уриалан дуудсан цорын ганц нууц

хэвлэлийн хувиар мөнхөрч үлдсэн бол “Үнэн” сонин нь Монголд ангич, намч хэвлэлийн эх үүсвэрийг тавин практикт баталгаажуулсан хэвлэл болж түүхэнд орсныг ч бас хамтад тэмдэглэсэн билээ.

Үнэн байдал хэдийгээр ийм боловч Монгол дахь ардчилсан чөлөөт хэвлэл-лийн эх ундарга нь бүр 1913 оноос үүдэлтэй юм. Туул гол Тэрэлжийн өврөөс эх авдгийн адил Монголын хэвлэл “Шинэ толь хэмээх бичиг” сониноос үүсэн салбарлаж өнөөг хүргэсэн нь бодит үнэн билээ. Үүнээс өмнө хаант орос, манжийн засгийн газраас монголчуудад зориулж монгол хэл дээр нэг бус сонин, сэтгүүл гаргаж байсан ч монголчууд өөрсдийн хүч, оюунаар бие даан гаргасан анхны чөлөөт хэвлэл нь 1913 оны 3 дугаар сарын 6-ны өдрийн “Шинэ толь хэмээх бичиг” юм. Үүнийг С.Идшинноров зэрэг манай зарим түүхч эрдэмтдийн оновчтой тодорхойлж бичсэнчлэн “Монголчуудын оюуны эцэг” хэмээн нэрлэгддэг Жамсраны Цэвээн тэргүүтэй монголын дэвшилт сэхээтнүүд үүсгэн буй болгожээ. “Шинэ толь хэмээх бичиг” сонин үүссэн түүх нь ч өөрөө маш өвөрмөц сонин юм. Анх хэвлэгдэхдээ 23-

15 см-ийн хэмжээгээр 30-40 хуудастай гарчээ. Эхний дөрвөн дугаар нь ингэж хэвлэгдсэн байдаг. Дараагийн дугаарууд нь 34-26 см-ийн хэмжээгээр 6-10 нүүртэй гарчээ. Үүнээс харахад эхлээд сэтгүүлийн, залгуулаад сонины хэлбэртэй гарсан гэж хэлж болно. Өөрөөр хэлбэл "Шинэ толь хэмээх бичиг" нь сонины ч, сэтгүүлийн ч нийтлэг хэв шинжийг өөртөө агуулж байсан байна. 1914 оны 8 дугаар сарын 21-нийг хүртэл нийт 20 дугаар гаргажээ. Нэг дугаарын тоо ширхэг нь 500 хувь байсан бөгөөд Гадаад Монголын төр, засгийн байгууллагуудад үнэ төлбөргүй тардаг, харин иргэдэд бол пүүсээр дамжуулан худалдан борлуулдаг байсан байна.

Энэхүү сониныг Хүрээнд дэх Оросын Элчингийн дэргэдэх Орос, Монголын багахан хэвлэлийн газарт хэвлэдэг байсан бөгөөд цөөхөн хэвлэх машинтай, хорголжин барын өрөх үсгийн нөөцтэй байжээ. Ж.Цэвээн Монголд шинжлэх ухаан, соёлыг дэлгэрүүлэхэд сонин, сэтгүүлийн үүрэг асар их гэдгийг хамгаас түрүүлж ойлгоод Монгол, Оросын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрт оролцож явахдаа өөрөө санаачилга гарган сүүхэйчилж Монголд хэвлэлийн газар байгуулна гэсэн заалт оруулсан нь ингэж хэрэгжсэн байна. Тэр Петербург хотноо очиж эрхэм хүн В.Котвичээр зуучлуулан

байж монгол үсгийн тугалган хэвийг 440 рүблээр худалдан авч Хүрээнд эргэж ирээд түүн дээрээ суурилан (орос, монголын хэвлэх үйлдвэрийг түшиглэн) монгол сонин бичгийн хороог байгуулсан түүхтэй ажээ. Энэхүү хэвлэх үйлдвэр нь сүүлд хүрээгээ тэлсээр УБТЗ-ын хэвлэх үйлдвэр болж өргөжсөнийг доктор Г.Дэлэг "Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл" номондоо тэмдэглэсэн байдаг.

«
Ж.Цэвээн Монголд шинжлэх ухаан, соёлыг дэлгэрүүлэхэд сонин, сэтгүүлийн үүрэг асар их гэдгийг хамгаас түрүүлж ойлгоод Монгол, Оросын засгийн газар хоорондын гэрээ хэлэлцээрт оролцож явахдаа өөрөө санаачилга гарган сүүхэйчилж Монголд хэвлэлийн газар байгуулна гэсэн заалт оруулсан нь ингэж хэрэгжсэн байна
»

XX зууны Монгол туургатны дотроос мэдлэг оюун, авьяас билгээрээ товойн гарсан Ж.Цэвээн Монгол дахь сонины анхны хэвлэх үйлдвэрийг ийнхүү өөрийн хөрөнгөөр үүсгэн байгуулалцаад зогссонгүй, тэндээсээ гарах оюуны талх тариаг шууд өөрөө үйлдвэрлэн бүтээж эхэлсэн нь "Шинэ толь хэмээх бичиг" сонин байлаа. Энэхүү сонины 20 дугаараас № 3, 4 нь Улсын төв номын санд, № 1, 2 нь МАХН-ын номын сангийн фондонд, № 7-14 ба 19, 20 дахь дугаар нь Үндэсний архивийн газарт тус тус хадгалагдаж байна. Тэдгээрийг сэтгүүлч Б.Дашцэрэн гуай монгол галигаар нэгд нэгэнгүй тэмдэглэн буулгаж авсныг МУИС-ийн оюутан Н.Пүрэвсүрэн орчин цагийн кирилл үсэг рүү хөрвүүлжээ.

"Шинэ толь хэмээх бичиг" нэрийг Ж.Цэвээн өөрөө санаачлан оноож өгсөн нь ихээхэн учир утгатай бөгөөд тухайн

нийгмийн үйл амьдралын толь болохын сацуу шинэ дэвшилт бүхнийг дэлгэрүүлэхэд үндсэн зорилго нь оршиж байв. Дээр дурдсан 20 дугаарт эрхлэгч Ж.Цэвээний бичсэн өгүүлэл, тэмдэглэл бараг дугаар бүрт нийтлэгджээ. Эрдэм шинжилгээний өгүүлэл, томоохон нийтлэл, орчуулгыг Ж.Цэвээн голлон гүйцэтгэж, шүүмжлэлт өгүүлэл, иргэний нийтлэлийг Д.Бодоо, Засгийн газрын үйл ажиллагааны талаарх мэдээ сонсгол, Автономитын дээд, доод хурал, ардчиллын сэдэвтэй найрууллуудыг Д.Бадрахбаатар, шуурхай мэдээ мэдээллийг Жанцансамбуу нар бичдэг байсан байна. Ж. Цэвээний үүсгэн байгуулсан "Шинэ толь хэмээх бичиг" сониныг залгамжлагч нь 1915 оны 9 дүгээр сарын 1-нээс 1920 оны 1 дүгээр сарын 23 хүртэл зуу гаруй дугаар гаргасан "Нийслэл Хүрээний сонин бичиг" бөгөөд түүнийг мөн л тэрбээр удирдан чиглүүлж байжээ. Эрхлэгч Ж.Цэвээн эдгээр сонины "бодлого, үзэл санаа, агуулгыг хувьсгалт ардчилсан чиг баримжаатай болгосон" гэж манай нэрт түүхч Д.Дашжамц онцлон тэмдэглэсэн бол¹ доктор Г.Дэлэг "Шинэ толь хэмээх бичиг" Монголын тогтмол хэвлэлийн анхны эх үүсвэр, суурийг тавьжээ² хэмээн дүгнэсэн байна.

"Ж.Цэвээн Монгол оронд анхны чөлөөт хэвлэл үүсгэж, "Шинэ толь",

"Нийслэл Хүрээний сонин бичиг" зэрэг сонин сэтгүүлийг гаргаж улмаар "Үнэн" сониныг анхлан гаргах ажилд оролцсон билээ" гэж доктор Ж.Цэцэгмаа³ тэмдэглэсэн бол доктор Л.Норовсүрэн "Түүхэн үнэнийг хүндэтгэе" өгүүлэл болон эрдэм шинжилгээний бага хуралд тавьж хэлэлцүүлсэн илтгэлдээ Ж.Цэвээнийг монголын анхны хэвлэлийг үүсгэн байгуулагч, ХХ зууны их соён гэгээрүүлэгч гэдгийг ерээд оны ардчилсан хэвлэлтэй холбон авч үзэж түүхэн үнэнийг мартаггүй байхыг уриалсан байна⁴.

«
Эл сонин Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэж хөгжлийн гэрэлт ирээдүйг мөрөөдөн бусад улс орны тухай өргөн дэлгэр нийтэлж байв
 »

Доктор, профессор М.Зулькафиль өөрийн бүтээлд "Шинэ толь хэмээх бичиг" сонин нийтлэлийн бодлого, тусгах сэдэв, харъяаллын хувьд чөлөөт хэвлэлийн шинж тэмдгийг өөртөө агуулж байсныг тэмдэглээд Ж.Цэвээн нарын өгүүлэлд "Богд гэгээний засгийн газрын үнэн нүүр царайг илчилж, нийгмийн амьдралын бодит байдлыг харуулж, ард түмний төлөө анхаарал санаа тавьдаггүй, авах идэхийн мөн болж суудаг ноёд сайдыг хатуу ширүүн шүүмжилж эхлэсэн нь ...цоо шинэ зүйл байв" хэмээн тэмдэглэсэн⁵ байхад судлаач Г.Жамсранжав "Сэтгүүлчдийн ууган нь хэн бэ?" өгүүлэлдээ эрхлэгч Ж.Цэвээн өөрийн сонинд ажиллаж байсан Догсомын Бодоо, Буниагийн Дорж нарын зэрэг эрх чөлөөний төлөө тэмцэгч, ардчилсан сэтгүүлчдийг эрх баригчдын дайралтаас хэрхэн яаж

хамгаалдаг байсан талаар маш сонирхолтой баримт дурдсан байдаг билээ.

"Шинэ толь хэмээх бичиг" сонин. Эрхлэгч Ж.Цэвээн Монгол Улсын дундах байдлыг шүүмжилбээ" хэмээх өгүүлэлдээ "Бод хэвч эзний хайрласан тунгалаг нэр, хүчд хишиг, хэтэрхий цалинг хүртсэний дээр олон албат боолын өргөл татварыг мөлжин хураан хэрэглээд улсын хэргийг үнэн санааны угаас явуулахгүй, биеэ өргөмжлүүлэхийг бодогч этгээдийг Богд эзэн томилбол ямар болно" гэх зэргээр бичсэн бол 1914 оны 20 дахь дугартаа "Монголын дээд доод хоёр хурлын дотор тогтоогдсон дүрэм хэмжээ огт үгүй. Аливаа хэрэг зөвлөх хэлэлцэхэд журамгүй гэлцэнэ. Дээд хуралд 50-60 сайд ноёд цуглах боловч хэдхэн тэргүүн сайд дарангуйлан шийтгэх тул хурлын зөвлөгөөг хоосоор аваачих нь олон гэнэ. Доод хуралд далаас наян хүн цуглах боловч дарга үгүй тул нэг хэдхэн дэд түшмэл даран-гуйлан шийтгэнэ" гэх букуу эсвэл "Монголын зарим идэрхэн сайд ноёдын аашлахыг үзэхүл тоглоом наадамд ирсэн залуусаас өөрцгүй ажээ. Эдний цээжинд нь улс төрийн ашиг тус хэмээхээс урьд амраг хатад, охидын зүс царай орно. Улс төрийн хэрэг яаваас сайн билээ гэж огт зовохгүй харин тэрний хүүхэн тийм, энэний хатан ийм, би энд, чи тэнд хэмээлдэнэ" гэх зэргээр бичиж байжээ.

Үүнээс үзвэл уг сонин засаг төрийн эрх баригчдын үйл ажиллагааг чөлөөтэйгээр шүүмжилж чадаж байсан нь нэн тодорхой харагдаж байна. Энэ нь Монголын анхны хэвлэл "Шинэ толь хэмээх бичиг" засгийн газраас хараат бус нийтлэ-

лийн бие даасан бодлого явуулж байсан баталгаа мөн. Тэр ч биггий хэл "Шинэ толь хэмээх бичиг" сонин Богдын Засгийн газрынхан Англиас хар тамхи оруулж ирсэн сан хөрөнгөө арвитгах гэсэн оролдлогын зад шүүмжлэн зогсоож чадсан удаатай билээ.

Эл сонин Монгол Улсын тусгаар тогтнолын төлөө тэмцэж хөгжлийн гэрэлт ирээдүйг мөрөөдөн бусад улс орны тухай өргөн дэлгэр нийтэлж байв. Харанхуй бүдүүлгийг гэтлэн давж, шинэ цагийн соёл боловсрол, эрүүлийг хамгаалах, шинжлэх ухааныг Монголд дэлгэрүүлэхийг "Шинэ толь хэмээх бичиг" чухалчлан үзэж байв. Тус сонины анхны дугаарт "Ертөнцийн байдал төлөв" гэсэн шинжлэх ухааны товчхон өгүүлэл нийтлэгджээ. Түүнд "Манай энэ суугаа ертөнцийн орны дүрс байдал нь бөөрөнхий бөгөөд хийн бүрхэвчтэй, хүрд мэт өнхрөн эргэнэ. Өдөр шөнөд нэг удаа эргэсээр энэ мэт явж нарыг нэгэнт тойрч гүйцвэл нэг жил гэнэ. Бөөрөнхий ертөнцийн орны нарны зүг хандсан талыг өдөр хэмээн, нөгөө сүүдэр этгээдийг шөнө гэнэ. Сар газрыг нэг удаа тойрон эргэж гүйцвэл нэг сар болов гэнэ. Бас газар нэг удаа өнхрөн өдөр шөнийн хорин дөрвөн цаг өнхөрч нэг хоног болно.

Бөөрөнхий газрын нарны зүг чиглэсэн хувийг халууны орон гэх, түүний хоёр талыг сэрүүний орон гэж, бас урд хойт хоёр оройг хүйтэн орон гэнэ. Манай монгол орон дэлхийн бүслүүр дэх халуун орны хойт этгээдийн сэрүүн оронд байна. Халуун оронд бол хүний сүүдэр доош хандаж толгой дээгүүр нар эргэнэ" гэжээ. Энэхүү сурталчилгаа нь тухайн үедээ

ихэнх монголчуудын бараг олж сонсоогүй шинэ сонин мэдээлэл байв. Мөн сонины "Хүйтэн, халуун, салхи, үүл, хур бороо, цас тэргүүтний учир" хэмээх өгүүлэлд манай бөөрөнхий дэлхий дээр нарны гэрэл хэдий эгц тусвал төдий халуун байх тул халуун, сэрүүн, хүйтний улиралтай орон гэж ялгана. Мөн халуун хүйтэн хоёрт шүтэн салхи хөдлөх, салхинд туугдаж үүл явах, сэрүүнээс үүлэн доторх усны уур нийлэлдэж борооны дусал болон буух ба хүйтнээс усны уур нийлэлдэн хөлдөж цас болж унана. Далайгаас алслан холдсон газар орны улирал нь зуны цаг үлэмж халуун, өвөл үлэмж хүйтэн байх бөгөөд үүнийг хуурай эх газрын улиралтай, бас өндөр газар нь сэрүүн, нам газраа дулаан улиралтай байх ёсыг мэдэх хэрэгтэй" гэжээ. Тэнгэрийн дуу бол луу могойн хүрхрэлт бус, харин үүлэн дээр цахилгааны хүч хуран цугларч эр, эм бүхий харш цэнэгүүд ойртон мөргөлдөх тохиолдолд хурц цахилгаан гялбаж нүргэлсэн их дуу чимээ гарна гэх зэргээр тэнгэрийн дуу, цахилгааны учрыг тайлбарлажээ.

Өөр нэг сонин жишээ иш татья. "Хүний насны учир" хэмээх гарчигтай өгүүлэлд "Дэлхий дээрх хүн нийтийн дөрвөн хувиас нэг хувь нь арван долоон нас хүрэлгүй үхдэг. Олонх нь гучин нас хүрэх тул одоо цагийн хүний нас гучин гурав гэнэ. Дэлхийн нэгэн мянган хүн дотроос зургаа нь жаран таван нас хүрнэ. Ганцхан нь зуу насална. Нас ийм ахар боловч шинжилбээс ариун цэвэр сахиж ядмаггүй бөгөөд сэтгэлээ барин чадвал ер хүн далан нас хүрмээр шинжтэй байна" гэжээ.

"Шинэ толь хэмээх бичиг" сонины шинжлэх ухааны чиглэлийн нийтлэлийг эрхлэн гаргагч Ж.Цэвээн өөрөө шууд хариуцан гүйцэтгэж байсныг дээр дурдсан билээ. Эдгээр нийтлэл нь тухайн цаг үеийн лам хуваргууд, ноёд дээдсийн олонхид огтхонч таалагдаагүй бөгөөд бурхан шашны ном сургаалд нь халдлаа гэж үзэж байсан тул тэрслүү үзэлт Ж.Цэвээний "Шинэ толь хэмээх бичиг" сониныг хаах оролдлого ч нэг бус удаа гарч байсан нь бодит үнэн юм. Энэ тухай М.Волосович "Азийн мэдээлэл" сэтгүүлд тэмдэглэн бичиж үлдээжээ.

"Нийслэл хүрээний сонин бичиг" сонин нь сүүлд "Шинэ толь хэмээх бичиг"-ийн шилдэг уламжлалыг өвлөн үргэлжлүүлж Монголд үндэсний хэвлэл үүсэн төлөвших үйл явцыг улам бататгаж өгсөн түүхтэй. Энэ сонинд Ж.Цэвээний "Шинэ толь хэмээх бичиг" дахь хамтран зүтгэгчид бараг бүгдээрээ ажиллаж байжээ.

"Шинэ толь хэмээх бичиг" ба "Нийслэл хүрээний сонин бичиг" хэмээх эл хоёр хэвлэл нь дэлхий дахинаа хаант бурангуй дэглэм задран унаж, хөрөнгөт ёс дэлгэрэн тогтож эхэлснийг Монголд анхалж мэдээлсэн үндэсний дэвшилт сонинууд бөгөөд монголчуудыг нойрноос сэрж бурангуй бүдүүлэг байдлаа халж бусад улс орны араас хөгжил дэвшлийн замд яаравчлахыг уйгагүй уриалж байсан байна.

Ж.Цэвээн бол Монголд үндэсний чөлөөт хэвлэлийг үүсгэн байгуулж төлөвшүүлэхэд шийдвэрлэх үүрэг гүйцэтгэсэн ХХ зууны их соён гэгээрүүлэгч сод бие хүн, нэрт сэтгүүлч байсан төдийгүй, Монголд өрнөсөн үндэсний ардчилсан хувьсгалыг

өрнүүлэхэд чухал нөлөө үзүүлсэн ардчилсан дэвшилт үзэлтэй сэхээтэн, монголын шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэгч анхдагч алтан хараацайнуудын нэг байсан билээ. Монголын сэргэн мандалтын ариун үйлсэд мартагдахын аргагүй жинтэй хувь нэмэр оруулсан энэ хүн МАН-ыг байгуулалцахад гар бие оролцож анхных нь гишүүдийн нэг болж, тус намын анхны программ болох "Түмэнд тунхаглан зарлах бичиг"-ийн эхийг зохион батлуулсан байна. Тэрбээр 1921 оны хувьсгал ялсны дараа Ардын Засгийн газрын Дотоод Яамны дэд сайдаар гурван жил, 1921-1923 онд Судар бичгийн хүрээлэнгийн гишүүн, эрдэмтэн нарийн бичгийн даргаар, 1924 онд Ардыг гэгээрүүлэх Яам байгуулахад анхных нь зөвлөх түшмэлээр ажиллаж байв. Тэр 1923-1925 онд НТХ-ны тэргүүлэгч гишүүн, 1925-1928 онд Намын хянан байцаах төв комиссын орлогч, тэргүүлэгчээр сонгогдож, 1924-1925 онд Улсын Бага Хурлын гишүүнээр ажиллаж шинэ Монгол Улсын төлөө бие сэтгэл хайргүй зүтгэжээ.

Ж.Цэвээн Монгол Улсын анхны Үндсэн хуулийн төсөл боловсруулах ажилд идэвхтэй оролцсон хүний нэг бөгөөд Монгол Улсын Бага Хурал ба Ардын засгийн газрын тухай, Богд Хааны тухай, Ард түмний эрх, үүргийн тухай, Олон зах, хил хязгаарын тухай, Монголын эрх баригчдын тухай, Үндсэн хуулийг засаж залруулахын тухай, Гадаадаас зэрэг цол хүлээхийн учир гэсэн 7 бүлэг, 23 зүйл бүхий түүний бичсэн Үндсэн хуулийн гар ноорог нь Монгол Улсын төв архивт эдүгээ хадгалагдаж байна.

Монголын нэрт соён гэгээрүүлэгч Ж.Цэвээн XX зууны эхээр "...ард албатны мунхаг харанхуйг эрдмийн зул бадруулж гийгүүлсүгэй" хэмээн бичиж байсан бөгөөд Европ ба Оросод алдаршсан зуу гаруй нам, сурах бичиг, товхимлыг олж цуглуулан Монголд авчирч орчуулж түгээх буянтай үйлсийг сайн нөхдийн хамт биечлэн хэрэгжүүл-жээ. Энэ тухай түүний түүвэр зохиолын 1 дүгээр ботид эмхэтгэн хэвлүүлэгчид нь:

1. Дэлхийн газарзүйн байдлаар - 10 орчим ном, товхимол,
2. Түмэн бодис-түүхийн цувралаар - 40 орчим,
3. "Эхлэлт" хэмээх шинжлэх ухааны талаар - 5 ном,
4. Соёлын түүхийн цуврал - 5 ном,
5. Тооны ухаан (арифметик, геометр г.м) - 5 ном,
6. Социализмийн үзэл суртлаар - 3 ном,
7. Хүн төрөлхтөний түүхэн асуудлаар - 4 ном,
8. Сод их хүмүүсийн намтар 25 орчмыг бүгд 100 гаруй ном, товхимлыг" хэмээн тэмдэглэжээ.

Монголд орчин цагийн шинжлэх ухааныг хөгжүүлж, цэцэгжүүлэхийн төлөө насан турш хичээнгүйлэн зүтгэсэн Ж.Цэвээн Монголын шинжилгээний ажлыг гадаадтай, ялангуяа ЗХУ-ын шинжлэх ухааны байгууллага, нэрт эрдэмтэдтэй холбох их ажлыг хийжээ. 1921 оны 11 дүгээр сарын 09-ний өдрийн Засгийн газрын 22-р хурлаас "Эрдэмт түшмэл Жамсрановоос бодолхийлэн зааварлаж..." зөвлөснөөр Судар бичгийн хүрээлэнг

байгуулж, тэдний санаачлан хэлснээр анхны даргаар нь О.Жамьян, эрдэмтэн нарийн бичгийн даргаар нь Ж.Цэвээнийг тохоон томилсон тухай өгүүлжээ. Энэ их эрдэмт хүнийг Монголд төдийгүй, ЗХУ-д ихэд үнэлэн хүндэтгэдэг байсан агаад 1936 онд түүнд Хэл шинжлэлийн ухааны докторын зэрэг хүртээж, дараахан нь ЗСБНХУ-ын ШУА-ийн сурвалжлагч гишүүнээр сонгож байсан байна.

Гучаад оны сүүлчээр болсон хил-мэгдүүлэлтийн хар шуурга Ж.Цэвээнийг тойроогүй бөгөөд 1937 онд түүнийг баривчилж, 1940 онд цаазалжээ. 1956 онд цагаатгагдсан аж.

Монгол Улс, түүний тусгаар тогтнолын төлөө хоёргүй сэтгэлээр туйлбартай зүтгэж, Монгол эх орондоо шинэ цагийн соёл, боловсрол, эрүүл мэнд, шинжлэх ухааныг үүсгэн хөгжүүлэх гайхамшигт үйлсийг оройлон манлайлагчдын нэг Ж.Цэвээний үүсгэн байгуулсан "Шинэ толь хэмээх бичиг" сонины анхны дугаар хэвлэгдэн гарсан 1913 оны 3 дугаар сарын 6-ны өдөр Монголын хэвлэлийн түүхэнд алтан хуудас болж мөнхрөн үлджээ. Ардчилал, шинэчлэлийн үйлс дэлгэрэн цэцэглэсэн 1992 оны 5 дугаар сарын 15-ны өдөр Улаанбаатар хотноо хуралдсан МСХ-ны VII их хуралд оролцогч Монголын сэтгүүлчид хоёрхон заалттай нэгэн чухал санал дэвшүүлжээ. "Монголын хэвлэлийн

өдрийг тэмдэглэж байх тухай" гэсэн гарчигтай энэхүү баримт бичигт:

Нэг. Түүхэн үнэнийг хүндэтгэн тогтоох зарчмыг эрхэмлэн сэтгүүлчид, олон түмний санал бодолд тулгуурлан монголчууд бие даан 1913 оны 6 дугаар сарын 6-наас эхлэн 1914 оны 8 дугаар сарын 21 хүртэл нийслэл хүрэнээ гаргаж байсан "Шинэ толь хэмээх бичиг"-ийг Монгол үндэсний тогтмол хэвлэлийн анхдагч гэж үзэж, жил бүрийн 3 дугаар сарын 6-ныг Монголын

хэвлэлийн өдөр болгон тэмдэглэж байх санал дэвшүүлж байна.

Хоёр. Алив тэмдэглэлт өдрийг тогтоох асуудлыг төрөөс шийдвэрлэх журам гарсан тохиолдолд энэхүү саналыг үндэслэн

тухайн цагт нь дээд газрын шийдвэр гаргуулахыг Монголын сэтгүүлчдийн холбооны удирдлагад зөвлөж байна хэмээн тэмдэглэжээ.

Энэхүү сэтгүүлчдийн их хуралд бибээр өөрийн биеэр суулцаж хамтран зүтгэгч Ц.Мөнхжаргал, Л.Норовсүрэн зэрэг сайн нөхдийн хамт санал төсөл боловсруулалцаж байсан билээ. Харамсалтай нь тухайн сэтгүүлчдийн байгууллагад үүссэн задрал бутрал дээрх саналыг хэрэгжүүлэх бодит бололцоо олгоогүй юм.

Ө нөөдөр байдал өөр болжээ. Монголын сэтгүүлчдийн хоёр байгууллага нэгдэж МСНЭ-ийг байгуулав. Ийм түүхэн чухал цаг үед одоогоос арван жилийн

«
МСНЭ-ийн Гүйцэтгэх хорооны гишүүдийн сүүлчийн хурлаас сэтгүүлчдийн уран бүтээлийн дээд шагнал нь Монголын сэтгүүл зүйг үүсгэн байгуулагч Ж.Цэвээний нэрэмжит байхаар тогтсон нь үүний нэг баталгаа болох буй заа.
»

өмнө дэвшүүлж байсан дээрх саналыг төр, засагт өргөн мэдүүлж баталгаажуулахын зэрэгцээ шинэ Монгол Улсын түүхэнд анхны ардчилсан чөлөөт сонин сэтгүүлийг санаачлан гаргаж тогтмол хэвлэлийг үүсгэж, Монголын сэтгүүлчдийн өгсөж өөдлөх зам харгуйг тавьж засалцаж өгсөн эрхэм эрдэмтэн сэтгүүлч Ж.Цэвээний алдар нэрийг мөнхлөн үлдээх сайн цаг иржээ гэж бодож байна.

МСНЭ-ийн Гүйцэтгэх хорооны гишүүдийн сүүлчийн хурлаас сэтгүүлчдийн уран бүтээлийн дээд шагнал нь Монголын сэтгүүл зүйг үүсгэн байгуулагч Ж.Цэвээний нэрэмжит байхаар тогтсон нь үүний нэг баталгаа болох буй заа. Энэхүү шагнал нь харьцуулан зүйрлэвээс утга зохиолын салбарт олгодог Д.Нацагдоржийн шагналтай адилхан юм. МСНЭ-ийн уран бүтээлийн комиссын дүгнэлт болон хэвлэл, мэдээллийн газруудын саналыг үндэслэн Засгийн газрын тогтоолоор байгуулагдсан. Боловсрол, соёл шинжлэх ухааны сайдаар толгойлуулсан уран бүтээлийн тусгай комиссоос Ж.Цэвээний нэрэмжит сэтгүүлчдийн дээд шагналыг уран бүтээлийн онцгой амжилт гаргасан нэгээс хоёр сэтгүүлчид жил бүр олгож байх нь зүйтэй болов уу. Учир нь Монголын сэтгүүлчдийн халуун ам бүл мянгаас хол давж, хоёр мянга руу нэгэнт гулсан оржээ. Тийм болохоор хоёр жилд нэг удаа нэгээс хоёр хүнд олгодог. Д.Нацагдоржийн шагналтай цаг хугацааны хувьд адилтгаж боломгүй санагдана.

1. Цэвээн Ж. 1997. Түүвэр зохиолууд. УБ. 12 дахь тал.
2. Дэлэг Г. 1965. Монголын тогтмол хэвлэлийн түүхэн тэмдэглэл. УБ. 66 дахь тал.
3. Цэвээн Ж. 2000. Түүвэр зохиолууд. УБ. 3 дахь тал.
4. "Сэтгүүлч". № 3 (83). 1993.
5. Монгол дахь чөлөөт сэтгүүл зүйн зарим асуудал. УБ. 2002. 50, 51 дэх тал.
6. "Үнэн". 1995.04.07. № 24 (18388).